

**“МОННООС”**  
**ҮЙЛДВЭР ХУДАЛДААНЫ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА**  
**ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ТОГТООЛ**

2021 оны 8-р сарын 28-ны өдөр

Дугаар 04/21

Улаанбаатар хот

Компанийн хөрөнгийг худалдаж,  
хөрөнгийг дагалдуулан газар  
эзэмших эрхийг шилжүүлэх тухай

Дэлхий нийтийг хамарсан цар тахлын улмаас, Монгол улсад илэрсэн тохиолдлын тоо өсч, олон удаагийн хөл хорионоос, компани нь ямар ч орлогогүй болж, бусдад их хэмжээний өр үүссэн, банкинд төлөх өр зээл нэмэгдсэн зэрэг санхүүгийн хүндрэлийг компанийн зарим хөрөнгө, зарим газрын эрхийг худалдаж орлогын эх үүсвэр гаргах талаар гаргасан ТУЗ-ийн 07.21 тоот тогтоолыг дэмжүүлэх асуудлаар “Монноос” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн 2021 оны 8 дугаар сарын 28-ны өдрийн ээлжит бус хурлаар хэдэлцээд гаргасан хувьцаа эзэмшигчдийн саналын дүн, ээлжит бус хурлын тооллогын комиссын 02.21 тоот тогтоолыг үндэслэн, Монгол улсын “Компанийн тухай хууль”-ийн 63 дугаар зүйлийг удирдлага болгон ТОГТООХ НЬ:

1. Хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцогчдын 244379 санал буюу ердийн олонхийн 100%-ийн саналаар Компанийн барилга, газрын эрхийн зарим хэсгийг худалдан борлуулах зөвшөөрлийг Гүйцэтгэх захирал /Х.Эрдэнэбаяр/-д зөвшөөрсүгэй.
2. Худалдан борлуулах хөрөнгийн үнийн доод хязгаарыг 35,000,000,000 /Гучин таван таван тэрбум/ төгрөгөөр баталсугай.
3. Үл хөдлөх хөрөнгийн байрлах эзэмшил газрын эрхийг дагалдуулан бусдад шилжүүлэх зөвшөөрлийг Гүйцэтгэх захирал /Х.Эрдэнэбаяр/-д олгосугай.
4. Хувьцаа эзэмшигчдийн хурлаас гаргасан шийдвэрийг хэрэгжүүлж, хөрөнгө худалдах үйл ажиллагааг зохион байгуулж, ТУЗ-д тухай бүр ажлаа тайлагнаж ажиллахыг Гүйцэтгэх захирал /Х.Эрдэнэбаяр/-д, хөрөнгө худалдах үйл ажиллагааны эрсдэлгүй байдлыг ханган, хяналт удирдлагаар хангаж ажиллахыг ТУЗ /Билл Холдсворд/-д тус тус үүрэг болгосугай.

Хурлын дарга

Тооллогын комиссын дарга



Б.Цолмон

Э.Тогосмаа